


60



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.4, Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын явцын талаар улирал бүр танилцуулж, 2024 оны эхний хагас жилд багтаан дуусгах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан төсөл, арга хэмжээг дуусгахад шаардлагатай үлдэгдэл санхүүжилтийг нийгмийн хариуцлагын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-аас шийдвэрлэх талаар зохих арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн), гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт даалгасугай.

3.Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ашиглалттай холбогдон гарах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, засвар үйлчилгээг хариуцаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН